

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны хуралдаанаас 2015 онд гаргасан шийдвэрүүд:

1. 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тогтоол:

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.6, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-д хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал О.Ганбаатарт үүрэг болгосугай.

Хоёр. Дотоод аудитын хорооны тогтоолоор батлагдсан аудитын зөвлөмжийн дагуу байгууллагад учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, компанийн эрх бүхий албан тушаалтануудад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, 2015 оны 2 дугаар улиралд багтаан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Х.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

Зөвлөмжүүд:

1. Компанийн үйл ажиллагаанд хараат бусаар үнэлэлт, зөвлөмж гаргах дотоод аудиторыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороотой зөвшилцөж аудит хийх гэрээг байгуулан хуулийн хүрээнд авч ажиллуулах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг жилд 2-3 удаа явуулж, шалгалтын үр дүнг холбогдох дээд байгууллагад тайлангах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс 1, үндсэн гишүүдээс ядаж 1 гишүүнийг эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй хүнийг томилох асуудлыг холбогдох удирдах газруудад тавьж шийдвэрлүүлэх.
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, санхүүгийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулах
5. Компанийн удирдах болон санхүүгийн ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хууль эрх зүйн сургалтад хамруулах, чадавхижуулах.
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтуудыг зөрчиж ерөнхий нягтлан бодогчоор ажиллуулахаар гаргасан ГУЗ-ын тогтоол, гүйцэтгэх захирлын тушаалыг хүчингүй болгож Ч.Орхоныг үүрэгт ажлаас нь чөлөөлж, дээрх хуулийн заалтуудын шаардлагыг хангасан ажилтныг томилох.
7. Дулааны үнэд хаасан 854,000 төгрөгийг гүйцэтгэх захирал О.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч Ч.Орхон нараар төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох.

8. Ажиллагсадын амралттай холбоотой дутуу бодсон цалингийн зөрүү 29,274,200 төгрөгийг нөхөн олгож, нийгмийн даатгалд дутуу тооцсон 3,805,646 төгрөгийг Нийгмийн даатгалд шилжүүлэн төлбөр тооцоог барагдуулах.
9. Дутуу нүүрсийг бусдад худалдсан, хувьдаа завшсан эсэхийг тогтоолгож байгууллагыг хохиролгүй болгох асуудлыг хуулийн байгууллагаар шийдүүлэх.
10. 9968,6 кг буюу 16,9 сая төгрөгийн дизель түлшийг анхан шатны баримтгүйгээр зардалд бүртгэсэн нь нягтлан бодох бүртгэлийн хуулийг санаатайгаар зөрчиж санхүүгийн тайланг буруу гаргаж хувьцаа эзэмшигч, бусад хэрэглэгч нарт ташаа мэдээлл өгч байгаа тул ерөнхий нягтлан бодогчид хариуцлага тооцож, мэргэшсэн нягтлан бодогчийг томилон ажиллуулахыг зөвлөж байна.
11. Алдангийн урамшуулал гэж удирдлагын түвшний албан тушаалтнууд өөрсдийгөө шагнасан 7,9 сая төгрөгийг гүйцэтгэх захирал О.Ганбаатар, ерөнхий нягтлан бодогч Ч.Орхон нараар төлүүлж компанийг хохиролгүй болгох.
12. Ажилчдыг шагнах нэрийн дор урлагын тоглолтыг ивээн тэтгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 –т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн гүйцэтгэх захиралд ажлын хариуцлага тооцож, зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах.
13. “Шарын гол” ХХК-д 50,0 сая төгрөгийн өглөг үүсгэж, алдагдлыг 50,0 сая төгрөгийг нэмэгдүүлэх ёстой байтал нягтлан бодох бүртгэлийн хуулийг санаатайгаар зөрчиж санхүүгийн тайланг буруу гаргаж хувьцаа эзэмшигч, бусад хэрэглэгч нарт ташаа мэдээлэл өгч байгаа тул ерөнхий нягтлан бодогчид хариуцлага тооцож, мэргэшсэн нягтлан бодогчийг томилон ажиллуулах, мөн ахлах нягтлан бодогч Б.Цэцэгмаад ажлын хариуцлага тооцох.
14. Компанийн удирдлага зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт хийх тухай гүйцэтгэх захирлын 2014 оны 03 дугаар сарын 04 өдрийн б/30 дугаар тоот тушаал нь хүчин төгөлдөр бус тушаал тул хүчингүй болгох.
15. Сангийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 125 дугаар тушаалаар баталсан харьцуулалтын аргаар бараа, ажлын үнийн санал авах тендерийн жишиг баримт бичгийг авах журмыг санаатайгаар зөрчсөн гэж үзсэн тул албан тушаалын давуу байдлыг ашигласан байх болон улмаар байгууллагад их хэмжээний хохирол учруулсан байх магадлалтай тул хуулийн байгууллагаар шалгуулах
16. “СПГАН” ХХКомпанид 3 төрлийн нийт 170,0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг өгч хийлгүүлсэн үйлдэл нь Авилгын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн:
 - 3.1.2-т “ашиг хонжоо” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;
 - 3.1.3. “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

-3.1.4.“давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг –зэрэг нэр томъёоны заалтанд хамрагдах нөхцлийг бүрдүүлэх боломжийг бий болгож байгаа тул Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Авилгатай тэмцэх газарт мэдээлэх үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн аудитын баг үзсэн болно.

2. 2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын тогтоол:

Аудитын дүн, зөвлөмжийг батлах тухай

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.6, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ХХК-д хийсэн дотоод аудитын дүн, зөвлөмжийг тус тус баталсугай.

Хоёр. Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д даалгасугай.

Зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.6, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /н.Сэр-од/, Гүйцэтгэх захирал /н.Занданхүү/ нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Дотоод аудитын хорооны тогтоолоор батлагдсан аудитын зөвлөмжийн дагуу байгууллагад учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, компанийн эрх бүхий албан тушаалтануудад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, 2015 оны 4 дүгээр улиралд багтаан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /н.Сэр-од/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д даалгасугай.

Зөвлөмжүүд:

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАТАЛСАН ЗӨВЛӨМЖИЙГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Тус компанийн зүгээс “ӨБЦТС” ТӨХК-иас авах 322,4 сая төгрөгийн авлагатай холбоотой төлбөрийг хуваан төлөх “ДэдЦС” ТӨХК-ийн хоорондын маргаантай асуудлыг ТУЗ-аараа дамжуулан ТӨХ-д асуудлыг тавьсан хэдий ч одоог хүртэл шийдвэрлүүлж чадаагүй байна. Энэхүү асуудал нь өөрөө өмчийн болон санхүүгийн, татварын гэх мэт асуудлыг давхар шийдвэрлэх тул ТӨХ нь дангаар шийдвэрлэх боломжгүй тул өр төлбөр үүссэн нөхцөл байдлыг бодитоор судлан шийдвэр гаргах эрх бүхий байгууллага болох Эрчим хүчний яам, Төрийн өмчийн хороо, Сангийн яам гэсэн хувьцаа эзэмшигч нарын оролцоотой ажлын хэсгийг байгуулуулж авлагыг барагдуулах эздийн /компанийн/ хувь хэмжээ, тоо, дүнг тогтоох, авлага барагдуулах арга хэмжээний эцсийн шийдвэрийг гаргах ажлын хэсгийг байгуулж, шийдвэр гаргуулах.
2. “ЦДҮС” ТӨХК, “Клин-Энержи” ХХК / НЬЮКОМ ХХК/-тай 2010 оны 12-р сарын 06-нд хийсэн “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай нэмэлт өөрчлөлт оруулсан тухай” гэрээг байгуулан 2013 оны 6 дугаар сараас эхлэн цахилгаан эрчим хүч худалдан авч үйл ажиллагаа явуулж ирсэн байна. “ДҮТ” компанийн диспитчерийн зохицуулалтаас шалтгаалан хязгаарласан эрчим хүчний асуудлаас хамааралтай маргаантай асуудал гарсан байна. Тухайлбал: Эрчим хүчийг хязгаарласанаас хамаарч “ЦДҮС” ТӨХК нь , “Клин-Энержи” ХХК-д хязгаарласан эрчим хүчний төлбөр 896,6 мянган ам.доллар, орлого дутуу төвлөрүүлэлтэд тооцсон алдангийн төлбөр 1983,7 мянган ам.доллар төлөх болсон байна. Гэтэл “ЦДҮС” ТӨХК нь төлбөрийн эх үүсвэр байхгүй тул 2 талын гэрээ /4.3-р заалт/-д өөрчлөлт оруулах саналыг цаад компанид хүргүүлсэн хэдий ч шийдвэрлэгдээгүй байгаа болно. Иймд дээрхи маргаантай асуудлыг Эрчим хүчний яамны Бодлого, зохицуулалт хэрэгжилтийн болон Санхүү, Хөрөнгө оруулалтын газар, холбогдох компанийн төлөөллийг оруулсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулж эцсийн шийдвэр гаргуулах.
3. Компанийн орон тоо, бүтцийн хувьд оновчтой зохион байгуулах, салбаруудын орон тооны давхардлыг арилгах.

4. Төв компани болон салбаруудын хоорондын үйл ажиллагааг зохицуулсан дүрэмд өөрчлөлт оруулах. Тухайлбал: Салбар нь хүний нөөцийн хувьд ажилд авах, ажлаас чөлөөлөх гэх мэт эрхтэй байгаа зэргийг дахин нягтлан үзэж зохицуулах.
5. Компанийн бизнес төлөвлөгөөг батлахдаа орлого нэмэгдүүлэх, зардлыг бууруулах зарчмыг баримтлах. Тухайлбал: Тэвчиж болох баяр ёслол, хүлээн авалт, биеийн тамир, урлаг соёл, шагнал урамшуулал, гадаад, дотоод томилолт гэх мэтийн зардлыг багасгах.
6. Компанийн их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлаас хэмнэсэн зардлын хөрөнгийг дахин өөр ажилд зарцуулахдаа Эрчим хүчний яам, Төрийн өмчийн хороогоор хянуулан батлуулж зарцуулах эрх авах.
7. Аудитаар гарсан зөрчилтэй холбоотой санхүүгийн ажилтнуудтай хууль, журамд заасны дагуу хариуцлага тооцох.
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос 2015 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2015 оны 4 улиралд багтаан хийж үр дүнг танилцуулах.
9. “ЦДҮС”ТӨХК нь 2014 оны бизнес төлөвлөгөөг МУИС-ийн Эдийн засгийн сургуультай гэрээ байгуулан 35.0 сая төгрөгөөр хийлгэж үргүй зардал гаргасан буруутай этгээдээр нөхөн төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох.

Зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.6, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-д хийсэн дотоод аудитын үр дүнд үндэслэсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч, биелэлтийг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ц.Баярбаатар/, Гүйцэтгэх захирал /Х.Цогтбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Батсайхан/-д даалгасугай.

Зөвлөмжүүд:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооноос аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

1. Компанийн үйл ажиллагаанд хараат бусаар үнэлэлт, зөвлөмж гаргах дотоод аудиторыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороотой зөвшилцөж аудит хийх гэрээг байгуулан хуулийн хүрээнд авч ажиллуулах.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг жилд 2-3 удаа явуулж, шалгалтын үр дүнг холбогдох дээд байгууллагад тайлагнах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй гишүүн байх шаардлагатай байна.
4. Монгол улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолд заасны дагуу зардлыг хэмнэж үр ашиггүй зардал гаргахгүй байх, тавилга эд хогшил худалдан авахгүй байх, цалин нэмэхгүй байх зэрэг энэхүү тогтоолын заалт бүрийг чандлан мөрдөж ажиллах,
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “ эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах”-гэсэн заалтыг хэрэгжүүлж авлага, өглөгийн үлдэгдлийг хариуцагч бүртэй тайлант хугацаа бүрийн эцэст тооцоо нийлж актаар баталгаажуулах, үр дүнг бүртгэл тайланд үнэн зөв тусгах
6. Тодотголыг хийхдээ бизнес төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын хэрэгцээ шаардлагыг тооцоо судалгаа, үндэслэл сайтай төлөвлөж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм стандартыг мөрдөж байх
7. Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгө, материалыг хөдөлгөөн гарсан тухай бүр орлого авч данс бүртгэлд тусгаж баталгаажуулах. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг зохих журмын дагуу бүрэн хөтөлж өмч эзэмшигчидэд картлан хариуцуулах.
8. Шагнал урамшуулал, тэтгэмж тусламж, бэлэг дурсгал олгох, хүлээн авалт, баярын арга хэмжээний зардал, гадны байгууллага хувь хүнд хандив, дэмжлэг олгох асуудлыг хууль тогтоомж, эрхийн актын хүрээнд нийцүүлэн мөрдөж ажиллах
9. Төлбөрийн чадварыг сайжруулах үүднээс урсгал авлагыг хугацаанд нь барагдуулах, он дамжин шийдвэрлэгдээгүй байгаа өр авлагыг хуулийн байгууллагад хандаж эцэслэн шийдвэрлүүлэх.
10. Тухайн жилд хөрөнгө оруулалтаар худалдан авах бараа ажил үйлчилгээг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон холбогдох журмын хүрээнд чанд мөрдөн ажиллах
11. Хөрөнгө оруулалт, засварын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, үндсэн хөрөнгө бэлтгэхэд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 5-р бүлгийн 24.3 дах заалтын дагуу Төрийн өмчийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байх.
12. Байгууллагын дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгож байгууллагын салбар, нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж ил тод нээлттэй ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх
13. Гэрээний үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, гэрээг тухай бүр дүгнэж байх, гэрээ, тендер хариуцсан ажилтнууд болон нягтлан бодогчдын мэргэжлийн зэрэг, ур чадварыг сайжруулах, сургалт зохион байгуулж хууль эрх зүйн мэдлэг хариуцлагыг дээшлүүлэх

14. Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002.06.25-ны өдрийн 171/111 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын дагуу баримтыг үйлдэж, мөнгөн хөрөнгийн орлого, зардлын гүйлгээний нотлох дагалдах дэмжих баримтуудын иж бүрэн байдалд ерөнхий нягтлан бодогч хяналт тавьж ажиллах
15. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, санхүүгийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулах
16. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2012 онд баталсан ДҮТ ХХК-ны дүрмийн 5 дугаар зүйлд “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь энгийн хувьцаанаас бүрдэх бөгөөд, үүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг гагцхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ” гэж заасны дагуу компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох газраар Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөлтийг оруулж, санхүүгийн байдлаарх тайлангийн үлдэгдэлтэй тохируулах
17. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС 16 болон компаниас батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зааснаар ашиглаж буй бүх үндсэн хөрөнгийн элэгдлийг бүрэн тооцож, тайлант хугацааны элэгдлийн зардлыг бүртгэлд үнэн зөвөөр залруулан тусгах, нэг ижил төрлийн ангилалын үндсэн хөрөнгөнд ижил хэмжээний элэгдлийн хувь хэмжээ тогтоож, тууштай мөрдөх -ЗЭРЭГ ЗӨВЛӨМЖИЙГ ДОТООД АУДИТЫН ХОРООГООР ХЭЛЭЛЦҮҮЛЭН ШИЙДВЭРЛҮҮЛЭХ.

2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын тогтоол:

Аудитын дүн, зөвлөмжийг батлах тухай

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.8, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Эрчим хүчний сайдын 2015 оны багц , “Алтай Улиастай Эрчим хүчний систем” ТӨХК-д хийсэн дотоод аудитын дүн, зөвлөмжийг тус тус баталсугай.

Хоёр. Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-д даалгасугай.

Зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.8, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Эрчим хүчний Сайдын багцын 2015 оны төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалт, худалдан авалт, санхүүгийн бусад үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчилтэй холбогдох албан тушаалтануудад хариуцлага тооцон, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Дэлгэрцогт/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Б.Ганхөлөг/ нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Дотоод аудитын хорооны тогтоолоор батлагдсан аудитын зөвлөмжийн дагуу эрх бүхий албан тушаалтануудад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, 2016 оны 2 дугаар улиралд багтаан дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-д даалгасугай.

Зөвлөмжүүд:

1. Санхүүгийн ажилтануудын удирдлагын бүтцийг хууль, журам, зааварт заасны дагуу оновчтой зохион байгуулах.
2. Санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, удирдлагаар хангах, санхүүгийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулах.
3. Санхүүгийн анхан шатны бүртгэлийн маягт, дагалдах, нотлох баримтын бүрдэлийг хангаж ажиллах
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах- Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримтлах.
5. Санхүү хөрөнгө оруулалтын газрын холбогдох ажилтанууд болон Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 94 дүгээр тушаалаар томилогдсон тооллогын комисс нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
6. Төрийн өмчит хувьцаат компаниудын худалдан авах ажиллагаанд Төрийн өмчийн хороо дангаар хяналт тавьж байгаа учир зохион байгуулалтын дотоод үйл ажиллагаанд Эрчим хүчний яам оролцох боломжгүй байна. Цаашид салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хувьд төрийн өмчит компаниудын худалдан авах ажиллагаанд хяналт тавих ажлыг анхааралдаа авч ажиллах.

Зөвлөмж хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.8, 10.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар

батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Алтай Улиастай эрчим хүчний систем” ТӨХК-д хийсэн дотоод аудитын үр дүнд үндэслэсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч, биелэлтийг 2016 оны 2 дугаар улиралд багтаан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Л.Ганхуяг/, Гүйцэтгэх захирал /Г.Чинбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-д даалгасугай.

Зөвлөмжүүд:

Дотоод аудитын 2016 оны төлөвлөгөө, төсөв батлах тухай

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1 дэхь хэсэг, Сангийн Сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.1 дэх заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Дотоод аудитын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, хорооны үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Дотоод аудитын хорооны үйл ажиллагаанд зориулагдах батлагдсан төсвийг холбогдох зардлаас гарган ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Дэлгэрцогт/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Б.Ганхөлөг/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-д даалгасугай.